320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	83,226,900.00	83,226,900.00	0.00	0.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,982,000.00	22,536,930.00	22,536,930.00	0.00
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0.00	0.00	0.00	0.00
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	37,982,000.00	22,536,930.00	22,536,930.00	0.00
34	ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	0.00	0.00
340001	Хүний хөгжил сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00	0.00	0.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	278,046,800.00	210,322,143.00	152,567,323.00	-4,561,200.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	144,568,100.00	210,322,143.00	148,006,123.00	0.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	0.00	0.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	133,478,700.00	0.00	4,561,200.00	-4,561,200.00
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	0.00	0.00	0.00
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	0.00	0.00	0.00	0.00
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	0.00	0.00	0.00	0.00
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	0.00	0.00
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	0.00	0.00	0.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	112,913,031.00	0.00	57,973,711.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	96,776,580.00	0.00	87,949,830.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,050.00	1,050.00	0.00	1,050.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.00	6.00	0.00	6.00
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00	0.00	6.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	0.00	0.00	0.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	173.00	173.00	0.00	173.00
620001	Удирдах ажилтан	13.00	13.00	0.00	13.00
620002	Гүйцэтгэх ажилтан	99.00	99.00	0.00	99.00
620003	Үйлчлэх ажилтан	36.00	36.00	0.00	36.00
620004	Гэрээт ажилтан	25.00	25.00	0.00	25.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	698.00	698.00	0.00	698.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН	448.00	448.00	0.00	448.00

	СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД				
630001	Төрийн өмчит ЕБС	448.00	448.00	0.00	448.00
630002	Хувийн ЕБС	0.00	0.00	0.00	0.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	250.00	250.00	0.00	250.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	250.00	250.00	0.00	250.00
631002	Хувийн өмчит СӨБ байгууллага	0.00	0.00	0.00	0.00
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	0.00	0.00	0.00	0.00
632001	Төрийн өмчит МСҮТ	0.00	0.00	0.00	0.00
632002	Хувийн МСҮТ	0.00	0.00	0.00	0.00
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	0.00	0.00	0.00	0.00
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	0.00	0.00	0.00	0.00
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо	0.00	0.00	0.00	0.00
640003	Хувийн эмнэлгээр эмчлүүлэгсдийн тоо	0.00	0.00	0.00	0.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	173.00	173.00	0.00	173.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	9.00	0.00	9.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	0.00	0.00	0.00	0.00
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	0.00	1.00	0.00	1.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	62.00	62.00	0.00	62.00
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	0.00	0.00	0.00	0.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	5.00	5.00	0.00	5.00
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	0.00	0.00	0.00	0.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	18.00	18.00	0.00	18.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	70.00	70.00	0.00	70.00
650010	Гэрээт ажилтан	2.00	2.00	0.00	2.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6.00	6.00	0.00	6.00
650012	Шүүгч, прокурор	0.00	0.00	0.00	0.00
650013	УТҮГ	0.00	0.00	0.00	0.00

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
-----	----------	--------------

II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	221,255,602.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	215,255,602.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	177,492,082.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,332,810.00
210104	Урамшуулал	18,332,810.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,978,550.00
210201	Тэтгэврийн даатгал	2,047,290.00
210202	Тэтгэмжийн даатгал	232,940.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	149,972.00
210204	Ажилгүйдлийн даатгал	82,468.00
210205	Эрүүл мэндийн даатгал	465,880.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,399,654.00
210401	Бичиг хэрэг	612,049.00
210402	Тээвэр, шатахуун	1,240,605.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	622,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,925,000.00
2105	Нормативт зардал	99,955,073.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	89,424,523.00
210502	Хоол, хүнс	10,530,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,626,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00
210604	Урсгал засвар	9,626,900.00
2107	Томилолт, зочны зардал	660,000.00
210702	Дотоод албан томилолт	660,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,703,595.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,703,595.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	835,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	835,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,763,520.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,350,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,350,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,413,520.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,413,520.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,000,000.00

I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	221,255,602.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	221,255,602.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,568,631.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,209,771.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,477,200.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Ууганбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тус тайланд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 16-аас 2022 оны 03 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Төрийн аудитын газрын ахлах аудитор гүйцэтгэж, менежер, дарга, тэргүүлэх аудитор нар хянаж баталгаажуулав.

Сэлэнгэ сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газар 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/49 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сэлэнгэ сумын засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төр засгийн бодлого шийдвэрийг сурталчлах, таниулах замаар төрийн үйлчилгээг жигд хүргэх, төр нийгмийн ажиллд иргэдийг өргөнөөр оролцуулах, тэдний үйл ажиллагааг идэвхижүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр 4 зорилтыг төлөвлөжээ. Үүнд:

- 2021 онд санхүүгийн сахилга хариуцлагын жил
- 3 “А” /архигүй, авилгагүй, аргацаахгүй/
- 3 “Х” /хурдтай, хариуцлагатай, хяналттай/
- 5 “Э” /хүнээ, малаа, ойгоо, орчноо, хөрсөө эрүүлжүүлэх/

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Сэлэнгэ сумын ТТЗ нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сэлэнгэ сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захиармжаар батлагдсан НБББББ-ыг 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа уг бодлогын бичиг баримт нь холбогдох стандарт, журмын дагуу боловсруулагдсан байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 4919.7 сая төгрөгөөр 2 хувь буюу 98.4 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгийн 5910.8 сая төгрөгийн 2 хувь буюу 118.2 сая төгрөг байхаар сонгон авч үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгийн дүнгээс тогтоож ажилласан болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 164.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 220.9 сая төгрөг ийн үлдэгдэлтэй тайлагнаж 56.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
<u>Касст байгаа бэлэн мөнгө</u>				
<u>Банканд байгаа бэлэн мөнгө</u>	0	0.01		
<u>Төрийн сангийн харилцах дансанд</u>	164.7	220.9	56.2	25.5
<u>Хадгаламж</u>	-	-	-	-
<u>Дүн</u>	164.7	220.9	56.2	25.5

Эх сурвалж: Мөнгөн хөрөнгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 220.9 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 0.01 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгөтэй холбоотой гарсан зөрчил илрээгүй болно.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 0.3 сая төгрөгийн, эцсийн үлдэгдэл 4.1 сая төгрөг болж, 3.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 2 Богино хугацаат хөрөнгө оруулалт, байгууллагаар /сая төгрөг/

<u>Байгууллага</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>
Татварын өглөг	0.3	0.9	0.6
Байгууллагад төлөх өглөг	0	0.4	0.4
Ажилчидтай холбоотой өглөг	0	2.4	2.4
Бусад	0	0.4	0.4
Дүн	0.3	4.1	3.8

Өглөгийг үлдэгдлийг байгууллага тус бүрээр нь харуулцал: Үүнд: Сумын ЭМТ нь 1.7, "Ингэт дөл" ОНӨААТҮГ 2.3 сая төгрөгийн тус тус өглөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар богино хугацаат өглөгтэй холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

3.5.3 Авлага

Авлагын эхний үлдэгдэл 245.6 сая төгрөгийн, эцсийн үлдэгдэл 345.4 сая төгрөг болж сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.3	0.3	0
Төлбөртэй үйлчилгээний авлага	0	0	0
Татаас, санхүүжилтийн авлага	0	122.8	122.8
Зээлийн хүүгийн авлага	23.7	16.7	-7
Татварын авлага	0.001	0.001	0
Байгууллагаас авах авлага	28.8	25.0	3.9
Хувь хүмүүсээс авах авлага	192.8	183.0	-9.8
Дүн	245.6	347.8	109.9

Эх сурвалж: Авлагын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх авлагаас сумын ЭМТ нь 120.4, цэцэрлэг 9.5, СХС-ийн 204.1 сая төгрөгийн авлагууд эзэлж байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай ЖДҮДСангийн 9.6 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд: Ингэт хөгжил сангийн 0.9, Баг хөгжүүлэх сангийн 3.8, Цэнгэл сангийн 4.8 сая төгрөгийн нийт 12 иргэний 2011, 2013, 2014 онуудад олгосон зээлийн үлдэгдлийг барагдуулж ажиллаагүй байна. Тус авлагыг барагдуулж ажиллах арга хэмжээг авч шүүхэд хандан шүүхийн шийдвэрээс хариуг хүлээж байгаа гэсэн тайлбарыг өгч байн

Аудитын илрүүлэлт:

Тус сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар авлагатай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа төлбөртэй холбоотой дансны авлага өглөг үүсээгүй болно.

3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Тус онд урт хугацаат хөрөнгө оруулалт хийгдээгүй болно.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 286.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 418.9 сая төгрөг болж, 132.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	12.3	88.4	76.1
Хангамжийн материал	260.6	319.0	58.4
Дүн	272.3	407.4	134.5

Эх сурвалж: Бараа материалын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материалыг 799.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэнээс төсвийн хөрөнгөөр 511.3 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, хандиваар 288.6 сая төгрөгийн бараа материал орлогод авч ажиллажээ.

Бараа материал өссөн үзүүлэлт нь ЭМЯ болон ЭМГ-аас эм боох материал шилжүүлэн өгсөнтэй холбон үзэж байна.

Мөн ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй 15.6 сая төгрөгийн бараа материалыг акталж данс бүртгэлээс хассан байна.

Аудитын илрүүлэлт: Сумын ТТЗ-ийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар алдаа зөрчил илрээгүй болно.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4223.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4923.1 сая төгрөг болж, 700.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4098.4	4794.4	696.0
Биет бус хөрөнгө	124.6	128.7	4.1
Дүн	4223.0	4923.1	700.1

Эх сурвалж: Үндсэн хөрөнгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 48.3 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 217.4 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 7.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн, балансаас балансад шилжүүлсэн 367.3 сая, акталсан 280.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд үлдэгдэл хөрөнгөгүй байна.

Аудитын илрүүлэлт:

ОНХС-гаар бэлтгэгдсэн 16.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж шилжүүлэхдээ НБББББ-ийн 4 дүгээр зүйлийн 4.6-д “хөрөнгө оруулалтын бүртгэл”-ийн дагуу бичилт хийгдээгүй зөрчил илэрлээ.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эхний үлдэгдэл 0.3 сая төгрөгийн, эцсийн үлдэгдэл 4.1 сая төгрөг болж, 3.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өссөн+ Буурсан -</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
<u>Богино хугацаат өр төлбөр дүн</u>	0.3	4.1	3.8	100
Татварын өглөг	0.3	0.9	0.6	15.8
Байгууллагад төлөх өглөг	0	0.4	0.4	10.5
Ажилчидтай холбоотой өглөг	0	2.4	2.4	63.2
Бусад	0	0.4	0.4	10.5
<u>Урт хугацаат өр төлбөр дүн</u>	0	0	0	0
	0	0	0	0
<u>Нийт дүн</u>				

Эх сурвалж: Өр төлбөрийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн дансанд 4.1 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Урт хугацаат өр төлбөрийн данс үлдэгдэлгүй болно.

Аудитын илрүүлэлт:

Өр төлбөртэй холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4919.4, эцсийн үлдэгдэл 5906.7 сая төгрөг болж сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГӨӨР/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт/+, бууралт -/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
<u>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</u>	1595.6	1595.6	0	0
<u>Өмч /төрийн/ /ТӨҮГ/</u>	190.7	347.5	156.8	55
<u>Өмч /хувийн/ /ТӨҮГ/</u>				
<u>Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/</u>				
<u>Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/</u>				
<u>Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/</u>				
<u>Хуримтлагдсан үр дүн</u>	942.9	1781.2	838.3	52.9
<u>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</u>	2190.2	2182.4	-7.8	0.3
<u>Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү</u>				
<u>Бодлогын өөрчлөлт алдааны залруулга</u>				
<u>Дүн</u>	4919.4	5906.7	987.3	108

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5906.7 сая төгрөг болж 987.3 сая төгрөгөөр өссөн нь хандив тусламжаар авсан хөрөнгө нэмэгдсэнтэй холбон үзэж байна. Үүнд:

- Төрийн өмчийн дансны үлдэгдэл 347.9 сая төгрөг болж 156.8 сая төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлтэй холбон үзэж байна.
- Хувийн өмчийн дансны үлдэгдэлгүй болно.

- Хувьцааны дансны үлдэгдэлгүй болно.
- Халаасны хувьцааны дансны үлдэгдэлгүй болно.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 2182.4 сая төгрөг болж 7.8 сая төгрөгөөр буурсан нь элэгдэл нь дуусаагүй хөрөнгө акталж данснаас хассантай холбон үзэж байна.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэлгүй болно.

Хуримтлагдсан үр дүн 1781.2 сая төгрөг болж 838.4 сая төгрөгөөр өссөн хөрөнгө нэмэгдсэнтэй холбон үзэж байна.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд 156.7 сая төгрөгийн залруулга хийгдсэн нь “Ингэт дөл” ОНӨААТҮГ нь сумын ЗДТГ-аас авто машины орлогыг балансаас балансад шилжүүлж авсантай холбогдуулан залруулгын бичилт хийгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Засгийн газрын хувь оролцооны данстай холбоотой алдаа зөрчил илрээгүй болно.

3.5.10 Орлогын данс

Сэлэнгэ сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар тусламж санхүүжилтийн орлого 3477.7, татварын бус орлого 1313.6, татварын орлого 258.1 сая төгрөгийн буюу нийт 5049.4 сая төгрөгийн орлого орсноор тайлагнажээ. Нийт үйл ажиллагааны орлогоос санхүүжилтийн орлого 69, татварын орлого 5, татварын бус орлого 26 хувийг тус тус эзэлж байна.

Сумын төсвийн орлогыг татварын 12, татварын бус 2 төрлийн орлогуудад ангилан нийт орлогыг 192.3 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 266.9 сая төгрөгийн орлого оруулж 74.6 сая төгрөгөөр орлого илүү оруулсан боловч орлогын төлөвлөгөөнд үл хөдлөх хөрөнгийн татварын орлого, малд ногдуулах албан татварын орлогуудыг сумын төсвийн орлогын төлөвлөгөөнд төлөвлөж батлуулаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын төсвийн орлогыг жилийн орлогын төлөвлөгөөнд дутуу тусгаж батлуулсан, орлого дутуу оруулсан 47.1 сая төгрөгийн зөрчил төлбөрийн акт 1, 1 зөвлөмж хүргүүлж ажилласан.

3.5.11 Зардлын данс

Зардлын дансадтай холбоотой 9.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

Сумын ЗДТГ нь 0.9 сая төгрөгийн цалин, ХХОАТ, НДШ-тэй холбоотой зардлуудыг шууд зардлаар бичиж тайлагнасан зөрчилд 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага тус тус бичсэн байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын /орон нутгийн / төсвийн орлого бүрдүүлэлт

Сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Орон нутгийн төсөв батлах”, 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн “2021 оны төсөт өөрчлөлт оруулах тухай” IV/03 тоот тогтоолоор сумын төсвийн орлогыг 192.3 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 266.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж орлогын төлөвлөгөөг 39 хувиар илүү биелүүлсэн байна.

Сумын төсөвт байгууллагуудаас соёлын төв өөрийн үйл ажиллагааны орлогыг 0.9, ЗДТГ нь 0.03, ИТХ 3.0 сая төгрөгөөр тус тус төлөвлөж гүйцэтгэлээр ИТХ 0.2 сая төгрөгөөр илүү, ЗДТГ 0.06 сая төгрөгөөр дутуу орлого бүрдүүлж ажиллажээ.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Соёлын төв	0.9	0.9	0	100
ЗДТГ	0.3	0.2	0.1	90
ИТХ	3.0	3.2	0.2	106
Нийт дүн	4.2	4.3	0.1	98.7

Тус сумын 6 төсөвт байгууллагуудаас 3 төсөвт байгууллага нь өөрийн үйл ажиллагааны орлогыг 4.2 сая төгрөгөөр төлөвлөж 0.1 сая төгрөгөөр илүү орлого оруулжээ.

Төсвийн төлөвлөлт

Тус сумын төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 278.0, НДСангаас 37.9, орон нутгийн төсвөөс 781.2, улсын төсвөөс 2079.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 3176.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 119.4 сая төгрөгөөр бууруулж 3057.4 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь улсын төсвийн санхүүжилт 42.3, НДСангаас 15.4, төсөвт байгууллагын үйл ажиллагааны санхүүжилт 67.7 сая төгрөгөөр тус тус зардлыг бууруулж баталжээ.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 19 арга хэмжээнд 3176.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 3128.5 сая төгрөгийг урсгал зардалд, 48.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2860.7 сая төгрөгийг улсын /орон нутгийн төсвөөс, 37.9 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 278.0 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 2824.6 сая төгрөгийг улсын /орон нутгийн төсвөөс, 22.5 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 210.3 сая төгрөгийн, нийт 3057.4 сая төгрөгийн санхүүжилтийг авч төлөвлөснөөс зардал 119.4 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 210.3 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 65.7 сая төгрөгөөр давсан нь өөрийн үйл ажиллагааны орлогыг дутуу төлөвлөсөнтэй холбон үзэж байна.

Туслах үйл ажиллагааны орлого төлөвлөөгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3078.5 сая төгрөг буюу 96.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнд хэмнэгдсэн зардлуудаас дурьдвал:

Цалин хөлс нэмэгдэл цалинд 1950.3, НДШ-ийн зардалд 256.4, тогтмол зардалд 205.8, томилолтын зардалд 4.5, төлбөр хураамжийн зардалд 24.2, урсгал зардалд 107.6 сая төгрөгийг нийт 2548.8 сая төгрөгийг зарцуулж төлөвлөсөн зардлаас 51.8 сая төгрөгийг хэмнэж ажиллажээ.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн тайлангаар 221.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч гүйцэтгэлээр 218.8 сая төгрөгийг зарцуулж 2.4 сая төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлжээ.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлэх мэдээллүүдийг бүрэн мэдээлж ажиллажээ.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 238.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 372.0 сая төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	0	0	0	0			0
Албан шаардлага	1	238.8	1	238.8			100
Зөвлөмж	5	372.0	5	372.0			100
Нийт	6	610.8	6	610.8			100

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа сумын 6 төсөвт байгууллага, 1 төрийн /орон нутгийн/ өмчит аж ахуйн нэгж, 4 тусгайн сангийн нийт 11 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 8 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд сумын ЗДТГ, ИТХ, ЭМТ, сургууль, цэцэрлэг, соёлын төв гэсэн 6 төсөвт байгууллагуудад санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Тус сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд залрууллагын алдаа илрээгүй болно.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Тус сумын БХС-гийн зарцуулалтыг түүвэрлэн шалгахад золбин ноход, муур устгах ажилд 306010 төгрөгийн шатахуун зарцуулсан гэж тайлагнасан боловч шатахуун авсан баримт байхгүй, жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй, хаашаа, хэдэн багт ажилласан нь тодорхой бус, анхан шатны баримтын бүрдэл дутуу зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 13.1. “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх,

санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй тул холбогдох хуулийн заалтад нийцэхгүй, үнэн зөв, бодитой байх батламж мэдээдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт бичлээ.

Тус сумын төсвийн орлогыг төвлөрүүлэн шалгахад малд ногдуулах албан татварыг 410 өрхийн 44727420, газрын төлбөрийн 2405109 төгрөг буюу нийт 47132529 төгрөгийн орлого дутуу төвлөрүүлж ажилласан нь 14 дүгээр 14.3-д “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.”, 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй тул холбогдох хуулийн заалтад нийцэхгүй, үнэн зөв, бодитой байх батламж мэдээдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт бичлээ.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 31.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 9.1 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 2.2 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 21.8 сая төгрөгийн 17 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 39.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүлээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал СХС, ЖДҮДС-гийн зээлийн үлдэгдэл, насжилт, эргэн төлөлтийг дараагийн аудитаар шалгах асуудалд оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 59.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 47.4 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 11.9 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч ажиллалаа.

4.1 Залруулсан алдаа

Залруулах алдаа илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

1. Тус сумын БХС-гийн зарцуулалтыг түүвэрлэн шалгахад золбин ноход, муур устгах ажилд 306010 төгрөгийн шатахуун зарцуулсан гэж тайлагнасан боловч шатахуун авсан баримт байхгүй, жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй, хаашаа, хэдэн багт ажилласан нь тодорхой бус, анхан шатны баримтын бүрдэл дутуу зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 13.1. “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

2. Тус сумын төсвийн орлогыг төвлөрүүлэн шалгахад малд ногдуулах албан татварыг 410 өрхийн 44727420, газрын төлбөрийн 2405109 төгрөг буюу нийт 47132529 төгрөгийн орлого дутуу төвлөрүүлж ажилласан нь 14 дүгээр 14.3-д “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.”, 41 дүгээр

зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн орлоготой холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үл хөдлөх хөрөнгө, малын хөлийн татварын орлогыг сумын төсвийн орлогод төлөвлөж батлуулаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Сумын төсвийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулан орлогыг бүрэн төлөвлөж ажиллах.

2. БХС-ын зарцуулалтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

БХС-гийн зарцуулалтыг зарцуулахдаа анхан шатны баримтын бүрдэл дутуу зарцуулсан.

2.2 Өгсөн зөвлөмж

НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг мөрдлөг болгож ажиллах.

3. ЖДҮДС-гийн зээлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

ЖДҮДС-гаас 2011, 2013, 2014 онуудад авсан зээл одоог хүртэл төлөгдөөгүй 9557050 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.2 Өгсөн зөвлөмж

ЖДҮДСангийн зээлийн үлдэгдлийг баталгаажуулан, холбогдох иргэдээс хуваарийн дагуу зээлийг төлүүлж, олон жил төлөгдөөгүй зээлийг бүрэн барагдуулах арга хэмжээг авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая/төгрөгөөр/

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ сумын ТТЗ	5	59.3	0	0	2	47.4	0	0	3	11.9